



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/7/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Дарга,гэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага.....	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ауд. 03. 25 № 87

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020999

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Handwritten signature of P. Mönхтогтох in black ink, written over a faint rectangular stamp.

Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	мянган төгрөгөөр	
			2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		763,252.1	1,037,453.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	290,413.2	457,059.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	195,444.6	263,317.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	277,394.3	317,076.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,739,637.7	2,659,081.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,739,637.7	2,659,081.2
39200	Биет хөрөнгө		2,602,533.7	2,522,129.2
39300	Биет бус хөрөнгө	13	137,104.0	136,952.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,502,889.8	3,696,534.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		37,201.4	20,246.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	37,201.4	20,246.8
41300	Өглөг	17а, 17б	37,201.4	20,246.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,465,688.4	3,676,287.8
51	Засгийн газрын хувь оролцоо		3,465,688.4	3,676,287.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,306,293.0	1,306,293.0
51200	Хуримтлагдсан үр дүн		1,260,632.2	1,471,231.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		898,763.2	898,763.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,502,889.8	3,696,534.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/ мянган төгрөгөөр/	
			2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,947,272.9	2,731,582.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		33,878.0	62,359.6
110	Орлогын албан татвар		28,389.0	18,195.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		28,389.0	18,195.4
113	Хөрөнгийн албан татвар		1,320.0	39,663.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		4,169.1	4,500.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	504,883.8	582,145.5
120	Нийтлэг татварын бус орлого		503,823.8	582,145.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,408,511.1	2,087,077.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,488,478.5	2,502,548.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,488,478.5	2,502,548.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,757,297.6	2,431,691.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,055,211.7	1,105,330.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		135,385.5	145,314.0

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		72,394.1	149,035.0
2104	Хангамж, бараа материалын зардал		73,156.9	96,908.3
2105	Нормативт зардал		76,927.4	252,492.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		45,515.7	83,201.2
2107	Томилт, зочны зардал		6,163.6	5,474.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		46,122.1	26,520.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		246,420.6	567,415.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		731,180.9	70,856.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,021,959.9	-	3,021,959.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	437.0	-	437.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,022,396.9	-	3,022,396.9
9	Тайлант үеийн үр дүн	443,291.6	-	443,291.6
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,465,688.4	-	3,465,688.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,465,688.4	-	3,465,688.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,700.0)	-	(4,700.0)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,460,988.4	-	3,460,988.4
19	Тайлант үеийн үр дүн	215,299.4	-	215,299.4
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,676,287.8	-	3,676,287.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,582,493.4	2,190,180.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	33,878.0	62,359.6
110	Орлогын албан татвар	28,389.0	18,195.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	28,389.0	18,195.4
113	Хөрөнгийн албан татвар	1,320.0	39,663.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,169.1	4,500.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,377.1	3,020.4
1181	Газрын төлбөр	792.0	1,480.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	140,104.3	186,743.3
120	Нийтлэг татварын бус орлого	139,044.3	186,743.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,408,511.1	1,941,077.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,311,376.1	1,969,049.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,311,376.1	1,969,049.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,577,664.3	1,896,663.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,055,626.0	1,104,311.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,332.2	145,367.3

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,055.0	148,861.4
2104	Хангамж, бараа материалын зардал	79,596.5	72,365.2
2105	Нормативт зардал	47,505.9	177,431.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,446.6	74,702.0
2107	Томилолт, зочны зардал	6,163.6	5,474.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,060.0	27,790.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,878.6	140,360.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	733,711.8	72,385.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	271,117.3	221,131.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	57,694.9	54,485.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	57,694.9	54,485.1
2200	Дотоод эх үүсвэрээр	57,694.9	54,485.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(57,694.9)	(54,485.1)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	102,822.4	166,646.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,590.8	290,413.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	290,413.2	457,059.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,231,098.9	1,770,508.3
УРСГАЛ ЗАРДАЛ	1,815,645.1	1,738,509.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,779,772.8	1,703,134.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,086,902.1	1,072,794.8
Үндсэн цалин	730,954.9	722,761.7
Нэмэгдэл	251,335.7	246,482.7
Унаа хоолны хөнгөлөлт	4,302.0	4,295.0
Урамшуулал	100,309.5	99,255.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	143,974.1	141,290.4
Тэтгэврийн даатгал	105,176.4	103,290.6
Тэтгэмжийн даатгал	10,124.7	9,930.7
ҮОМШӨ-ний даатгал	7,924.6	7,769.5
Ажилгүйдлийн даатгал	2,281.7	2,221.1
Эрүүл мэндийн даатгал	18,466.7	18,078.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,004.0	148,861.5
Гэрэл, цахилгаан	7,035.3	7,033.5
Түлш, халаалт	139,809.6	139,801.9
Цэвэр, бохир ус	2,159.1	2,026.1
Хангамж, бараа материалын зардал	66,657.8	66,623.9
Бичиг хэрэг	10,583.2	10,582.8
Тээвэр, шатахуун	26,361.7	26,351.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,957.6	1,957.0
Ном, хэвлэл	756.8	755.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,787.7	2,784.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,210.8	24,193.0
Нормативт зардал	66,278.0	66,270.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,526.4	37,524.6
Хоол, хүнс	22,107.6	22,102.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,644.0	6,644.0
Эд хогшил, урсгал засварын зардал	81,423.5	81,422.4
Багаж, техник, хэрэгсэл	14,491.0	14,491.0

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550.0	550.0
Урсгал засвар	66,382.5	66,381.4
Томилолт, зочны зардал	5,500.8	5,424.0
Дотоод албан томилолт	5,500.8	5,424.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,773.3	10,223.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,461.8	5,932.6
Даатгалын үйлчилгээ	609.2	592.5
Тээврийн хэрэгслийн татвар	398.6	397.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	121.0	121.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,495.0	1,495.0
Газрын төлбөр	295.7	292.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,392.0	1,392.0
Бараа үйлчилгээний бусад зардал	169,259.2	110,223.5
Бараа үйлчилгээний бусад зардал	162,157.5	103,143.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,101.7	7,080.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,872.3	35,375.2
Бусад урсгал шилжүүлэг	35,872.3	35,375.2
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,829.0	10,829.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,206.2	18,747.4
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	500.0	500.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,337.1	5,298.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	315,798.2	31,998.8
Бусад хөрөнгө	315,798.2	31,998.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,231,098.9	1,973,829.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,170,061.5	1,168,716.0
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,053,667.4	1,052,321.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	693,219.9	654,213.6
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	-
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,656.4	21,695.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,656.4	21,695.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	343,161.1	129,203.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,861.7	78,189.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,706.3	51,014.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	264,715.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,715.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	229,050.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,516.4
210102	Нэмэгдэл	24,879.5
210104	Урамшуулал	6,636.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,077.0
210201	Тэтгэврийн даатгал	2,785.7
210202	Тэтгэмжийн даатгал	327.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	262.2
210204	Ажилгүйдлийн даатгал	63.8

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	637.6
2104	Хангамж, бараа материалын зардал	7,318.1
210401	Бичиг хэрэг	1,098.3
210402	Тээвэр, шатахуун	1,911.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,311.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,896.1
2105	Нормативт зардал	111,161.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,802.9
210502	Хоол, хүнс	5,358.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,390.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,100.0
210604	Урсгал засвар	11,290.1
2107	Томилолт, зочны зардал	50.0
210702	Дотоод албан томилолт	50.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,567.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,567.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,970.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,820.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,150.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,664.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,264.8
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	6,264.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	264,724.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	264,724.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,640.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,727.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,356.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	8.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Луус сум нь эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж тасралтгүй сурталчлах алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд 2021 онд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй, өгөгдсөн зөвлөмж байхгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,512,332.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 25,123.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,586.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 193,644.8 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	290,413.2	457,059.4	166,646.2
Авлага	195,444.6	263,317.4	67,872.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	277,394.3	317,076.6	39,682.3
Үндсэн хөрөнгө	2,739,637.7	2,659,081.2	(80,556.5)
Нийт хөрөнгө	3,502,889.8	3,696,534.6	193,644.8
Өр төлбөр	37,201.4	20,246.8	(16,954.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,465,688.4	3,676,287.8	210,599.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,502,889.8	3,696,534.6	193,644.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 166,646.2 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 270,798.2 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч цар тахлын улмаас хил хаагдаж бараа бүтээгдэхүүний үнэ өссөн, зарим үйл ажиллагааг хязгаарлаж байснаас цаг хугацааны хувьд хойшлогдсон зэргээс шалтгаалан 12,000.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь нөлөөлсөн.

Авлагын дансны үлдэгдэл 67,872.2 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 156,988.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 39,682.3 мянган төгрөгөөр өссөн нь цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах хамгаалах хэрэгслийг Эрүүл мэндийн төвд хүлээн авч бүртгэж тайлагнасантай холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 32,165.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авч, хандиваар 103,302.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан 69,179.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 80,096.3 мянган төгрөгийн хөрөнгө актталж, шилжүүлж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,696,534.6 мянган төгрөг болж 193,644.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Луус сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 12 дугаар тогтоолоор Луус сум тайлант онд 109,800.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 119,899.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Хувь хүний орлогын албан татвар	13,500.0	12,295.4	(1,204.6)	91.1
Бууны албан татвар	1,300.0	1,150.0	(150.0)	88.5
Улсын тэмдэгтийн хураамж	1,426.1	1,426.0	(0.1)	100.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	196.6	196.6	-	100.0
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	3,200.0	5,900.0	2,700.0	184.4
Газрын төлбөр	1,100.0	1,480.2	380.2	134.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,942.8	1,397.8	(545.0)	71.9
Малд ногдуулах албан татвар	45,000.0	38,513.6	(6,486.4)	85.6
Дүн	67,665.5	62,359.6	(5,305.9)	163.1
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	31,834.5	37,648.0	5,813.5	118.3
Торгуулийн орлого	10,300.0	19,891.5	9,591.5	193.1
Дүн	42,134.5	57,539.5	15,405.0	136.6
Нийт дүн	109,800.0	119,899.1	10,099.1	109.2

Хувь хүний орлогын албан татвар 1,204.6 мянган төгрөгөөр, малын тоо толгой албан татвар 6,486.4 мянган төгрөгөөр тасарсан нь цар тахлын улмаас уул уурхайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа зогссон, байгалийн гамшгаас шалтгаалан малын тоо толгой буурсантай холбоотой байна..

Бууны албан татвар 150.0 мянган төгрөгөөр тасарсан шалтгаан нь төлөвлөгөөг бодитой биш баталснаас шалтгаалсан.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж 545.0 мянган төгрөгөөр тасарсан нь хог үүсгэсний төлбөр хураамж авах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол Хууль зүй яаманд хянагдаж оройтож ирсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Луус сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,046,388.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,046,388.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Луус сумын ИТХ-ын 2021 оны 23 болон 29 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 184,710.6 мянган төгрөгөөр өсгөж, 2,231,098.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд гарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт дутуу авснаас шалтгаалан бууруулан баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 40 арга хэмжээг санхүүжүүлэхээр урсгал зардалд 1,815,645.1 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 315,798.2 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлд 99,655.6 мянган төгрөг нийт зардлыг 2,231,098.9 мянган төгрөгөөр төлөвлөж баталжээ.

Нийт зардлын 1,053,667.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 693,219.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 24,656.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 116,394.1 мянган төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас 343,161.1 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,052,321.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 654,213.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21,695.6 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 129,203.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 116,394.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас тус тус төвлөрүүлж нийт 1,973,829.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн.

Үүнээс 1,738,509.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 31,998.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж 1,770,508.2 мянган төгрөг буюу 89.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан.

Санхүүжилтээс дутуу зарцуулсан 1,345.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 31,217.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 80,526.6 мянган төгрөг, хандиваар 12,640.0 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны орлогоос 26,751.8 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлогоос 144,805.6 мянган төгрөг, нийт 264,724.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин, НДШ-ийн зардалд 35,593.3 мянган төгрөг, томилолтын зардалд 50.0 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 7,318.1 мянган төгрөг, нормативт зардалд 111,161.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 13,390.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт 17,567.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 43,971.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 29,400.0 мянган төгрөг, нийт 258,450.7 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 6,264.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд 8.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нэмэлт санхүүжилтэд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой малчдад туслах 18,858.5 мянган төгрөгийн хандив орж ирснээс малын эрлийн шатахуун, сэг зэм устгах ажлын хөлсөнд 13,722.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,136.0 мянган төгрөгийг сумын Мал хамгаалах санд төвлөрүүлсэн.

Цар тахалтай холбоотой 22,962.4 мянган төгрөгийн хандив орж ирснээс 429.0 мянган төгрөгөөр маяак чанга яригч, 255.0 мянган төгрөгөөр холбооны зориулалтаар гар утас, 22,278.4 мянган төгрөгийг сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хүнс, хамгаалах хэрэгсэл зэрэгт зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Луус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хэвийн бус ажил гүйлгээ гараагүй.

Харин удирдлага зохион байгуулалтын хувьд доголдолтой, дотоод хяналт хангалтгүй аудитор өндөр шүүмжлэлтэй хандаж буй эрсдэлтэй асуудал нь аймгийн Эрүүл мэндийн газраас нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн орлогыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зарцуулалтад хяналт тавиагүй асуудал байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга нь 2021 онд нийт 3,824,459.4 мянган төгрөгийн 154 мэдээллээс 136 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, хугацаанд нь байршуулж, 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлүүдийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Луус сумын Засаг даргын Тамгын газар, Тусгай зориулалтын сангууд, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар нийт 38,418.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс

20,380.3 мянган төгрөгийн 10 алдааг залруулж, 2,400.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 15,638.5 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 12,747.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	4,542.1	4	4,542.1			100
Албан шаардлага	12	9,389.0	12	9,389.0			100
Зөвлөмж							
Нийт	16	13,931.1	16	13,931.1			100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахуун, хүнсний материал, Эрүүл мэндийн төвийн эмийн зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Ерөнхий боловсролын сургууль, Засаг даргын Тамгын газрын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 83,428.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 57,875.1 мянган төгрөгийн 16 алдааг аудитын явцад залруулж, 40.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 9,874.8 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага, 15,638.5 мянган төгрөгийн 6 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 30.7 хувийг залруулагдаагүй, 69.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 40.0 мянга буюу 0.1 хувь нь дотоод хяналт хариуцлагатай холбоотой, 60,039.4 мянга буюу 71.9 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 23,349.0 мянган төгрөг буюу 28.0 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь нягтлан бодогч нарын ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаар нийт 5,191.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 534.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,657.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөв захирагч нарын санхүүгийн тайланг нэгтгэхдээ 534.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн тооцоог илүү тайлагнасан

4.2 Албан шаардлага

1. Хувь хүнээс авах 4,657.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 4,657.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
3	ЕБС	1						1			
4	ЭМТ	2						1		1	
5	БХС	1	15,638.5							1	15,638.5
6	МХС	1	4,657.0					1	4,657.0		
7	дүн	5	20,294.5					3	4,657.0	2	15,638.5
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	ИТХ	2	701.4			1	40.0	1	661.4		
2	ЗДТГ	3	1,384.0	1	1,384.0					2	
3	ЭМТ	6	5,068.2	5	5,127.1					1	
4	ЕБС	7	51,515.5	5	46,969.1			2	4,556.4		
5	Цэцэрлэг	1	16.3	1	16.3						
6	Соёлын төв	1	594.6	1	594.6						
7	БХС	2	850.0	2	850.0						
8	МХС	2	2,400.0	1	2,400.0					1	
9	ТТЗ	1	534.0	1	534.0						
	дүн	25	63,132.9	15	57,875.1	-	-	3	3,061.4	2	-
	Нийт зөрчлийн дүн	30	83,428.4	17	57,875.1	1	40.0	6	9,874.8	6	15,638.5